



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/513

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, 65 дугаар зүйлийн 65.1.4, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 24 дүгээр зүйлийн 24.3, 24.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит XX хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Мөрөн сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ойр орчмын авто замын цагаан шугамыг тодруулах, шинээр хийх, анхааруулах болон мэдээлэх тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу хийж гүйцэтгэн хүүхэд багачуудын эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 19,000,000 (Арван есөн сая) төгрөгийн зардлыг аймгийн Замын сангийн нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар) нарт тус тус зөвшөөрсүгэй.

2. Дээрх ажлыг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Мөрөн сумын Засаг дарга (Д.Идэрмөнх)-д, арга зүй удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Должинсорогдог)-д тус тус даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Завиуулавч-2023

6712011134